



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Монгол Улсын Боловсролын Их Сургууль

Хөтөлбөрийн нэр: Боловсрол судлал

Индекс: D011101

Шинжээчийн баг:

Ахлагч: С.Эрдэнэтуул

Гишүүд: Ю.Хорлоо
С.Санжаабадам

Он сар өдөр: 2020.06.08

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Товчилсон үгийн тайлбар

-

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Монгол Улсын Боловсролын Их Сургууль Mongolian State University of the Education	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Боловсрол судлал	
Индекс	D011101	
Шинжээчид	<p>Багийн ахлагч</p> <p>1. С.Эрдэнэтуул Хүмүүнлэгийн Ухааны Их Сургуулийн Академик чиглэл эрхэлсэн дэд захирал</p> <p>Багийн гишүүд</p> <p>2. Ю.Хорлоо Монголын их дээд сургуулиудын консорциумын элсэлтийн төв комиссын зөвлөх, Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн багш</p> <p>3. С.Санжаабадам Боловсролын хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга</p>	
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	Г.Даваажаргал	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	02/13	Шинжээчидтэй гэрээ байгуулах
	02/14	Шинжээчдэд өөрийн үнэлгээний тайланг хавсралтын хамт хүлээлгэн өгнө.
	02/21	Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	05/27	Мэргэжилтэн сургууль дээр очиж шинжээч ажиллах бэлтгэлийг хангуулна.
	05/28, 29	Сургууль дээр очиж шинжээчид ажиллана.
	06/05	Шинжээчид үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	06/08	Шинжээчдийн үнэлгээний тайланг сургуульд илгээж санал авна.
	06/08	Сургууль үнэлгээний тайлантай танилцаж, тайлбар, нотлох баримтыг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	06/09	Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэнэ.

	Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар шинжээчийн үнэлгээний тайланг танилцуулж шийдвэрлүүлнэ.
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-өөс эрхлэн мөрдүүлж буй Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд мөрдөх заавар, журмууд, БСШУ-ны Сайдын 2016 оны 02 сарын 19-ний өдрийн А/53 тушаал, Шинжээчийн урьдчилсан үнэлгээний тайлан, Шинжээчийн үнэлгээний тайлан, холбогдох бусад заавар, эрхийн баримт бичиг, БМИҮЗ-ийн Ажлын албаны захирлын 2020 оны А/36 тушаал.

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Боловсролын салбарт багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжил, багшлахуй суралцахуйн шинэчлэл, ээлжит хичээлийн бэлтгэл, төлөвлөлт, хөтөлбөрийн шинэчлэл, сургалтын орчин хэрэглэгдэхүүний эрүүл аюулгүй байдал, сурах бичгийн агуулга, арга зүйн судалгаа, боловсруулалт, хичээлийн, суралцахуйн болон багшлахуйн үнэлгээ зэргийг судлан судалгааны үр дүнд тулгуурлан боловсролын салбарын удирдлага, боловсролын байгууллагын сургалт, үйл ажиллагааг сайжруулах хэрэгцээ шаардлага байна.

Монгол улсад орчин цагийн боловсролын салбар үүсэж хөгжсөн 100 шахам жилийн хугацаанд боловсролын салбарын мэргэжлийн судлаач, арга зүйчийг бэлтгэж байгаагүйн улмаас энэ салбарт ажиллах мэргэжлийн арга зүйч, судлаач дутмаг байна гэсэн үндэслэлээр энэхүү хөтөлбөрийг нээн, 2014–2015 оны хичээлийн жилээс элсэлт авч, сургалтыг зохион байгуулж байна.

Хөтөлбөрийн хувьд Засгийн газрын “Судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх хөтөлбөр”, “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”, “Үр дүнд суурилсан боловсролын хөтөлбөр”, МУБИС–ийн хөгжлийн бодлого зэрэгтэй нийцүүлэн төгсөгчдөд олгох мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлж, сургалтын төлөвлөгөө, хичээлүүдийг тодорхойлжээ. Сургалтын хөтөлбөрийг өнөөг хүртэл тасралтгүй сайжруулж, хөтөлбөрийн матриц, хичээл хоорондын уялдаа холбоог сайжруулах замаар сургалтын төлөвлөгөөнд 3 удаа сайжруулалт хийсэн байна.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- ОУ-д энэ чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж буй их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөр, сургалтын төлөвлөгөөнд хийсэн шинжилгээ
- Хөтөлбөрийн хэрэгцээг тодорхойлох зорилгоор боловсролын салбарт ажиллагчдаас авсан судалгааны тайлан

- Батлагдсан хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө
- Сургалтын хөтөлбөрийг хэлэлцсэн тэнхимийн болон хөтөлбөрийн хороодын хурлын протокол, шийдвэр

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн хэрэгцээг тодорхойлохдоо ЗГ–аас баримталж буй бодлого, боловсролын салбарт баримталж буй бодлого, хөдөлмөрийн зах зээлийн чиг хандлага зэргийг харгалзан үзсэн байна.
- Хөтөлбөрийн хэрэгцээг тодорхойлох асуулга судалгааг 2 удаа явуулж, судалгааны үр дүнд тулгуурлан хөтөлбөрийн зорилго, суралцахуйн зорилтот үр дүнг тодорхойлсон байна.
- Тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэнээс хойш хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүнг шинжлэх, сайжруулах ажлыг 3 удаа хийсэн байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн хэрэгцээг тодорхойлохдоо төгсөгчдийн ажиллах боломжит ажлын байруудыг тодорхойлсон боловч, эдгээр ажлын байрын эрэлт, хөдөлмөрийн эрэлтийн таамаглалыг хийгээгүй.
- ОУ–д магистрын түвшинд бэлтгэж буй мэргэжлийн бакалаврын түвшинд зайлшгүй хэрэгцээтэй байгааг нотлох судалгаа дутмаг.
- Багшийн ажлын байранд ажиллаж байгаа төгсөгчдөд судалгааны арга зүй болон зөвлөн туслах үйлчилгээний менежментийн ур чадвар шаардлагатай байгааг оролцогч талуудаас авсан судалгааны үр дүнгээс тодорхойлсон тул, бие даасан хөтөлбөр хэрэгжүүлэхээс илүүтэйгээр хөрвөх чадвар олгох боломж байгааг анхаарах
- Хичээлүүдийн суралцахуйн зорилтот үр дүн нь хөтөлбөрийн матрицад тусгагдсан суралцахуйн зорилтот үр дүнтэй зөрөх явдал байгааг дахин хянаж, засварлах

Зөвлөмж:

- Бакалавр, магистрын түвшний босоо холбоог тодорхой харуулж, төгсөгчдийн карьерын замналын боломжит хувилбар, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн таамаглалыг тооцож үзвэл илүү бодит хэрэгцээ нь тодорхойлогдоно.
- Багшийн хөтөлбөрөөр суралцагч нь хөрвөх чадварыг эзэмших боломж бас байгааг давхар бодолцож үзэх.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- МУБИС–ийн хөгжлийн бодлого
- Боловсрол судлалын сургуулийн стратеги, тэнхимийн төлөвлөгөө
- Хөтөлбөрийн хэрэгцээг тодорхойлох зорилгоор боловсролын салбарт ажиллагчдаас авсан судалгааны тайлан
- Батлагдсан хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө

- Хөтөлбөрийн үр дүнгийн матриц
- Хичээл хоорондын уялдааг харуулсан зураглал
- МУБИС – ийн “Сургалтын хөтөлбөр боловсруулах удирдамж”

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУБИС–ийн эрхэм зорилго, зорилгод нийцүүлэн хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон.
- Хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүнг 3 удаагийн сайжруулалт хийж, мэдлэг, чадвар, хандлагын нийт 52 үр дүнг тодорхойлон гаргасан.
- Төгсөгчийн ажиллах боломжит ажлын байруудыг тодорхойлж, тухайн ажлын байрны тодорхойлолт, мэргэжлийн стандартуудыг судлан төгсөгчийн загварыг боловсруулсан байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрөөр төгсөгчийн загвар нь зохистой тодорхойлогдсон эсэхийг ажил олгогч, мэргэжлийн экспертүүдээр үнэлүүлсэн, оролцогч талуудаас санал авсан байдал дутмаг.
- Бакалавр, магистрын хөтөлбөрийн залгамж холбоо, суралцахуйн зорилтот үр дүнгийн ялгаатай байдлыг илүү оновчтой байдлаар тодорхойлох.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн үр дүнгийн үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг тодорхой болгож, оролцогч талуудаас авах судалгааг тогтмолжуулах.

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрүүд
- Түүврээр “Судалгааны арга зүй”, “Боловсролын эдийн засаг”, “Хүний нөөцийн менежмент” хичээлүүдийн хэрэглэгдэхүүн
- Суралцагчдаас авсан сэтгэл ханамжийн судалгааны үр дүн
- Дадлагын удирдамжууд
- Хөтөлбөрийн матриц, хичээл хоорондын уялдааг харуулсан зураглал
- Сургалтын төлөвлөгөө, сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг хэлэлцсэн хурлын протокол
- Хичээлийн хөтөлбөрийг багш нараар үнэлүүлсэн үнэлгээний хуудаснууд

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын хөтөлбөр боловсруулах нэгдсэн удирдамж, эрх зүйн орчин тодорхой. МУБИС–ийн бакалаврын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал, хөтөлбөрийн

чанарын үнэлгээний удирдамж, сургалтын хөтөлбөр боловсруулах удирдамжийг боловсруулан ашиглаж байна.

- Сургалтын хөтөлбөр нь хөтөлбөрийн зорилго, зорилтууд, суралцахуйн зорилтот үр дүнгүүд, хичээлийн суралцахуйн үр дүнгүүд, хичээл хоорондын уялдаа холбоог харуулсан зураглал, хөтөлбөрийн матриц зэргийг бүрэн тодорхойлсон байна.
- Хөтөлбөрийн баримт бичгийг эмх цэгцтэй нэг загварын дагуу боловсруулж, баталгаажуулсан байна.

Анхаарах асуудал:

- Хичээлийн суралцахуйн зорилтот үр дүн, тухайн хөтөлбөрт оруулах хувь нэмрийг харахад харилцан адилгүй байгааг анхаарах. Суралцахуйн зорилтот үр дүнг хэт задалснаас 1 болон 2 кредиттэй хичээлүүд олон байгаагаас гадна хөтөлбөрийн матрицаас харахад хичээлүүдийн хөтөлбөрт оруулж буй хувь нэмрүүд хэт ялгаатай байна

Зөвлөмж:

- Хичээлүүдийн хөтөлбөрийн үр дүнд оруулж буй хувь нэмрийг тэнцвэржүүлэх.

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн хүрэх үр дүн болон хичээлийн хүрэх үр дүнгийн холбоо хамаарлын матриц
- Агуулгын залгамж холбоог илэрхийлсэн схем
- Боловсрол судлал мэргэжлийн дадлагын дэвтэр, Боловсрол судлаач, арга зүйчийн мэргэлийн дадлагын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийсэн нь , 2019 оны дипломын ажил
- Боловсрол судлал мэргэжлийн дадлагын дэвтэр
- Хөтөлбөр хөгжил хичээлийн семинар, бие даах ажлын удирдамж
- Оюутнуудтай хийсэн ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага

- Хөтөлбөрийг 4 удаа сайжруулсан.
- Оюутнууд удирдлагын мэдээллийн системээр хичээл сонголт I ба II-ыг хийж дадсан байна

- Цахим сургалтад 3 лекц бэлтгэсэн ба тайлангийн хугацаанд нэг хичээл цахимаар тавигдаж, төгсөх ангийн нийт 577 багшаас 158 оюутан хандаж, уг лекцийг сонссон байна.
- Удирдлагын ур чадвар хөгжүүлэх болон судалгааны арга зүйн дадлагыг боловсролын үндэсний болон орон нутгийн байгууллагууд дээр хийгддэг болгож байна.
- Лицей сургуулийн сургалтын үйл ажиллагаанд багш нар ажиглалт хийх боломжтой. Ажиглалтын үр дүнг сургалтад ашиглах талаар ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- Сургалтын хөтөлбөр судлалын оюутны дадлага ажлыг ерөнхий боловсролын багштай хамтран ажиллах талаар сайжруулах.
- Лицей сургуулийн сургалтын явцад хийсэн ажиглалтын багш нар жигд хийх, ажиглалтын үр дүнг оюутанд зориулсан сургалтад ашигладаг болоход тэнхим хамтран ажиллах.

Зөвлөмж:

- Оюутны дадлагад ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт шинжилгээ хийх, хөтөлбөрийн хөгжлийн чиглэлээр ерөнхий боловсролын сургуулийн багш нартай хамтран ажиллах чадварыг хөгжүүлэх үйл ажиллагааг тусгах.

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Боловсрол судлалын сургалтын хөтөлбөрийн арга зүйн шинжилгээ
- 2020 оны 5 сард батлагдсан сургалтын төлөвлөгөө. Сайжирсан хувилбар.
- Оюутны сурах ачааллын үнэлгээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Асуудалд суурилсан, төсөлд суурилсан, тохиолдолд суурилсан суралцахуйгаар мэргэжлийн мэдлэг, ур чадвар, үнэт зүйл хандлага нь мэдлэг бүтээх арга зүйгээр хөгжүүлэхэд стратегийг хөтөлбөрт баримталж байна. Мэргэжлийн мэдлэг, ур чадвар нь шинжлэх ухаанч байх зарчмыг баримталж байна.
- Ажиглалтын 6 лабораторид багш нар ажиллах боломжийг бүрдүүлсэн.
- Багш нар өөрийн хичээлдээ ажиглалт хийх технологийг ашиглах талаар ярилцаж байна. Ирэх хичээлийн жилээс 6 лабораторид нэвтрүүлж эхлэх бөгөөд БоСС хөтөлбөрт хичээл заадаг багш нарын хичээлийн ажиглалт хийгдэх боломж бүрдэнэ.
- Тухайн улиралд сонгогдсон хичээлийн 94 хувь нь заавал өмнөх хичээлтэй уялдаатай байсан тохиолдолд тухайн оюутны хичээл сонголт нь баталгааждаг. Энэ нь оюутны сонголтод хязгаарлалт үүсгэж, оюутны сурах хугацааг уртасгах талтайг тэнхим шүүмжлэлтэй хандаж, залгамж холбооны кодыг цөөрүүлэх чиглэлээр ажиллаж

байгаа юм. Энэ нь залгамж холбооны кодыг боловсронгуй бус байсантай холбоотой бэрхшээл үүсгэснийг арилгаж байна.

- Кр цагаас гадна оюутны бие даах ажил, эрдэм шинжилгээний хуралд оролцох ажил, мэргэжил сурталчлах гэх мэт олон талт үйл ажиллагаа нь 1 ба 2 дугаар курсийн оюутнуудад тодорхой хэмжээний ачаалал үүсгэдгийг тэнхим дүгнэж бөгөөд оюутныг дэмжих үйл ажиллагааг хувь хүний хөгжил, мэргэжлийн үнэ цэн, сонгон судлах хичээлийг зөвлөмж зэрэг чиглэлээр хийдэг.

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Тэнхимийн эрхлэгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл
- Даалгаврын сан
- Тэнхимийн уулзалт, хэлэлцүүлгийн протокол
- Багш нарын санал асуулгын судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Даалгаврын санг бүрдүүлэхдээ блүпринтийг сэргээн санах 15, ойлгох 15, хэрэглэх 25, задлан шинжлэх 25, үнэлэх 10, бүтээх 10 хувь эзлэхээр боловсруулсан.

Үнэлгээний даалгаврын тоо 500 байхаар хөтөлбөрийг хөгжүүлж эхлэхдээ зорилт тавьсан боловч одоогийн байдлаар чанарын шаардлага хангасан 99 даалгавар төгсөх шалгалтын хувьд байна.

Анхаарах асуудал:

- Үнэлэх, бүтээх даалгаврын боловсруулалтыг нэмэгдүүлэх боломжтой ч сургуулийн цахим үнэлгээний системд нээлттэй даалгавар тавигдахад бэрхшээлтэй байна.
- Санал асуулгын багш нараас авсан судалгаагаар үнэлгээний даалгавар боловсруулахад зөвлөгөө, семинар дутмаг байгааг дурдсанаас гадна 6 түвшний үнэлгээний залгамж холбоог тооцоход бэрхшээлтэй гэсэн байна.
- Чанарын шаардлага хангасан даалгаврын тоог нэмэгдүүлж чадахгүй байгаадаа тэнхим анхаарч ажиллаж байна.

Зөвлөмж:

- Үнэлэх, бүтээх даалгаврын боловсруулалтыг нэмэгдүүлэхэд тэнхим анхаарч ажиллаж байгаа нь зөв алхам. Харин цахим үнэлгээний системтэй хэрхэн уялдуулан ажиллаж, ашиглах боломж нэмэгдүүлэх талаар илүү тодорхой ажиллах
- Даалгаврын найдвартай болон баталгаат чанарыг хангах аргачлалыг хөгжүүлэх, энэ чиглэлээр багш нараа чадавхжуулах ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх.

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн байр, анги танхим, лабораторийн хүрэлцээ хангамж
- Эрүүл ахуй, аюулгүй байдлын журам
- Сургалтын орчны экологийн нөхцөл
- Зайны сургалтын төв
- Мультимедиа студийн үйл ажиллагаа
- Танхимын сургалтыг зайнаас ажиглах лаборатори
- Үнэлгээний төв
- Бие даан болон багаар ажиллах орчны хангалт
- Хөтөлбөр хэрэгжүүлэх орчныг сайжруулах, нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр сүүлийн жилүүдэд хийсэн ажлын төлөвлөгөө, тайлан

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Боловсрол судлал хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, оюутнууд тухайн хөтөлбөрөөр амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлж, сургалтын орчны стандарт шаардлагыг хангасан байна.

Анхаарах асуудал:

- Өөрийн үнэлгээний тайланд сургалтын тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, цахим орчны ашиглалт, хүртээмжийн талаар бичсэн боловч энэ талаар сэтгэл ханамжийн судалгаа авсан тухай дурдаагүй.

Зөвлөмж:

Сургалтын тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, цахим орчны ашиглалт, хүртээмж, сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг тайлагнаж хэвших

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын хэрэглэгдэхүүний нөөцийн жагсаалт, хүртээмж, ашиглалт
- Сургалтын цахим материал
- Тусгай хэрэгцээт боловсролын анги, танхим, үзүүлэн таниулах материал

- Багш нарын боловсруулсан цахим хичээл
- Лаборатори, кабинетад ажиллах журам

Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмжийн хүртээмж
Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын удирдлага, мэдээллийн системийн ULMS 3.0 системийг ашигладаг.
- Зайны сургалтын материал бэлтгэх мультимедиа студитэй, видео хурлын өрөөтэй.
- Оюутнуудын сургуулийн болон дүнгийн тодорхойлолт авдаг автомат машинтай.
- Танхимын сургалтыг зайнаас ажиглах лабораторитой, 120 компьютер бүхий үнэлгээний төвтэй.

Анхаарах асуудал:

- Сургалтын хэрэглэгдэхүүн, нөөц, хүртээмж, ашиглалтын талаар хийсэн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг тайланд тусгах

Зөвлөмж:

- E-контент түвшинд боловсруулсан сургалтын материалыг сайжруулах

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн судалгаа, хүртээмж, хэрэглээ
- Виртуал, дижитал видео, аудио болон бусад цахим эх үүсвэрүүдийн байдал
- Цахим орчны хүртээмж, хэрэглээ
- Сургалт, судалгааны лицензтэй программын ашиглалтын байдал
- Сургалтын орчны талаар төгсөгч, суралцагчид, багш нараас тогтмол судалгаа авч, дүгнэлт хийн сайжруулах чиглэлээр ажилладаг байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Тэнхимийн түвшинд ном, сурах бичгийн фондтой.
- Багш суралцагчдын сургалтын үйл ажиллагаанд шаардлагатай 183932 номын мэдээллийн санг цахим хэлбэрт оруулсан.

- Номын сан нь 216581 номын фондтой.

Зөвлөмж:

- Цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэрийн ашиглалтын судалгааг тогтмол хийж хэвших

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн хорооны журам
- МУБИС–ийн бүтэц, зохион байгуулалт
- Хөтөлбөрийн хороо байгуулсан тушаал, хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэл, шийдвэрүүд
- Тэнхимийн үйл ажиллагааны төлөвлөгөө
- Удирдлагын мэдээллийн систем

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн ерөнхий хороо, салбар хороо, дэд хороодууд ажиллаж, хөтөлбөрийг удирдлагаар хангаж, чанарын дотоод баталгаажуулалтыг хийж байна.
- Мэргэжлийн тэнхимээс хөтөлбөрийн ерөнхий хороонд 1 багш, дэд хороонд 5 багш, салбар хороонд 2 багш ажиллаж байна.
- Хөтөлбөрийн хорооны ажиллах журам, хичээлийн үнэлгээний удирдамж, шалгуур үзүүлэлтийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.
- Удирдлагын мэдээллийн системээр оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа болон бусад судалгааг авч, нэгдсэн санг бүрдүүлсэн байна.

Анхаарах асуудал:

- Оюутны санал, гомдлын нэгдсэн сан, түүнд хийсэн дүн шинжилгээ дутмаг

Зөвлөмж:

- Сэтгэл ханамжийн судалгааны үр дүн болон бусад оролцогч талуудаас авсан судалгаа, дүнгийн шинжилгээний үр дүнгийн талаар хэлэлцэж хэвших

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг

ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан дадлагын удирдамжууд
- Боловсролын байгууллагууд болон судалгаа, шинжилгээний хүрээлэнгүүдтэй байгуулсан гэрээ
- Төгсөгчдийн холбооны дүрэм, журам, төгсөгчдийн холбооны бүрэлдэхүүн
- Хамтарсан төслийн мэдээллүүд, төслийн баримт бичгүүд
- Багш нарыг гадаадад туршлага судлуулахаар явуулахад сургуулийн зүгээс дэмжлэг үзүүлсэн захирлын тушаал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, ЕБС–ууд болон Хонг Конгийн их сургууль, Японы их дээд сургуулиудтай хамтын ажиллагаатай ажиллаж байна.
- Оюутнуудыг дадлага хийлгэх дадлагын бааз сайтай, боловсролын салбарын байгууллагуудтай оюутан дадлага хийлгэх гэрээ байгуулж ажиллаж байна.
- Хамтын ажиллагаатай гадаадын их дээд сургуулиудад багш нараа туршлага судлуулахаар явуулснаас гадна, зөвлөх багш нараар хэд хэдэн удаагийн сургалтыг зохион байгуулсан байна.

Анхаарах асуудал:

- Зарим байгууллагатай байгуулсан дадлагын гэрээний хугацаа дууссан байгааг анхаарах
- Оюутныг дадлагад гаргаж буй байгууллагуудтай байгуулах гэрээний нэгдсэн загвар байхгүй байна.

Зөвлөмж:

- Гэрээг шинэчлэн байгуулах, хугацааг шинэчлэх
- Оюутан солилцоог эхлүүлэх тал дээр цаашид анхаарах
- Боловсролын салбарын гол судалгааны байгууллага болох боловсролын хүрээлэн, багшийн хөгжлийн институт зэрэг байгууллагуудтай хамтын ажиллагаагаа сайжруулах

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Эрдэм шинжилгээ, багш нарын хөгжилд зарцуулсан зардлын үзүүлэлт, захирлын тушаалууд
- Албан томилолтын талаар захирлын тушаалууд
- Оюутны үйлчилгээнд зарцуулсан зардлууд, оюутны холбооны төсөв

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Тэнхимийн багш нар орлогын олон талт эх үүсвэрийг бүрдүүлэх чиглэлээр санаачилгатай ажиллаж, бизнесийн байгууллагуудын захиалгаар сургалтыг хэд хэдэн удаа зохион байгуулсан байна.

Анхаарах асуудал:

- Тэнхимийн төсөв байхгүйгээс гэнэтийн үйл ажиллагаатай холбоотой зардлуудыг санхүүжүүлэхэд олон шат дамжих төвөгтэй байдал үүсэх
- Багшийн хөгжил, тэр дундаа эрдэм шинжилгээнд зарцуулсан зардлын эзлэх хувь сүүлийн 3 жилд буурсан дүнтэй байна.

Зөвлөмж:

- Орлогын эх үүсвэрийг олон хувилбартай болгох, солонгоруулах тал дээр багш нарыг идэвхжүүлэх
- Судалгаанд суурилсан их сургууль болон хөгжих эрхэм зорилгын хүрээнд эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулах зардлын хувийг нэмэгдүүлэх

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Сургуулийн веб хуудас
- Тэнхимийн багш нарын хэвлэл мэдээллийн хэрэгслээр өгсөн ярилцлага болон бусад сурталчилгааны материалууд
- Хөтөлбөрийн сурталчилгааны танилцуулга, брошур
- Тэнхимийн төлөвлөгөө

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Тэнхимийн багш нар хөтөлбөрийг олон нийтэд таниулах талаар олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр ярилцлага болон нийтлэлүүдийг 4 удаа хэвлүүлжээ.
- Тэнхимийн хүрээнд шинэ хөтөлбөрийг нийгэмд таниулах хөтөлбөрийг тэнхимийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна.

Анхаарах асуудал:

- Ажил олгогчдын төлөөлөлтэй ярилцахад, тухайн мэргэжлийн төгсөгчийн ажиллах боломжит ажлын байр, түүний онцлог давуу талын талаар ойлголт тааруухан байгааг анхаарах.

Зөвлөмж:

- Төгсөгчдийн ажил эрхлэлт, мөшгөх судалгааг тогтмол хийж, төгсөгчдийн давуу талыг нийгэмд таниулах
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг идэвхжүүлэх

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Сургуулийн веб хуудас
- Тэнхимийн багш нарын хэвлэл мэдээллийн хэрэгслээр өгсөн ярилцлага болон бусад сурталчилгааны материалууд
- Хөтөлбөрийн сурталчилгааны танилцуулга, брошур
- Тэнхимийн төлөвлөгөө

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУБИС – ийн нэгдсэн бодлогын хүрээнд МУБИС – ийн веб хуудас болон социал сүлжээгээр дамжуулан мэдээллийг хүргэж байна.

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- МУБИС-ийн хөгжлийн бодлого
- МУБИС-ийн оюутны журам
- БСШУСЯ-ны Оюутан элсүүлэх журам

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Элсэгчдийн дундаж оноо 576 байна.
- Бүх аймгаас элсэгчтэй.

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Боловсрол судлалын сургуулийн оюутны гарын авлага, хэвлэмэл болон цахим хэлбэрээр байна. 38 нүүр.
- Оюутны эрдэм шинжилгээний 2015-2019 онд 5 удаагийн хурлын 3 эмхэтгэл
- Тойм лекц унших 2017, 2018 оны намар, хаврын төлөвлөлт
- БСС, Боловсролын судалгаа арга зүйн тэнхимийн зөвлөх багш нар ангитайгаа хамтран ажилласан байдлыг үнэлэх үнэлгээний хуудас
- Зөвлөх багшийн ажлын үр дүнгийн биелэлтийн хуудас

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш оюутны нээлттэй харилцааны цахим хуудас байнгын ажиллагаатай.
- Оюутан хөгжүүлэх үйл ажиллагааны чиглэлээр мэдээлэл түгээх цахим хуудас ашиглагддаг.
- Хичээлийн жилийн эхэнд уг мэргэжлээр элсэгчдэд зориулсан тусгай мэдээлэл өгч, холбогдох мэдээллээр хангахдаа сонгон суралцах мэргэжлийн онцлог, хөрвөх боломжийг судлах хичээл, дадлагатай уялдуулан таниулдаг байна
- Жил бүр оюутанд чиглэсэн үйл ажиллагааны талаар сэтгэл ханамжийн судалгаа авч, үр дүнд тулгуурласан тухайн чиглэлийн үйл ажиллагааг сайжруулдаг байна
- Зөвлөх багш хичээл сонголт хийх, оюутны сурах, хүмүүжих үйл явцыг хянах, зөвлөн туслах, дүгнэх, оюутны ачаалал, сурах үйл явцыг төлөвлөх, оюутны үнэлж дүгнэх журам аргачлалыг танилцуулах үүрэгтэйгээр ажилладаг байна.
- Тэнхимд харьяалагдаж буй 78 оюутнаас 21 нь цагийн хөдөлмөр эрхэлж байгааг бөгөөд тэд өдөрт дунджаар 3 цаг ажилладаг байна. Тэднээс 4 оюутан судалгааны чиглэлээр ажил эрхэлсэн байна.

Анхаарах асуудал:

- Оюутныг ажлын байранд бэлтгэх, ажил олоход нь туслах хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлийн үйл ажиллагааг зохион байгуулах хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв байхгүй байна.

Зөвлөмж:

- Зөвлөх багшийн оюутантай ажилласан тэмдэглэл, тэнхимийн хүрээнд оюутнуудын асуудлыг хэрхэн шийдсэн талаар санг бүрдүүлж, хэлэлцэж хэвших.

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутны сэтгэл ханамжийн судалгаа
- Үйл ажиллагааны явцыг харуулсан зураг, мэдээнүүд
- Оюутны клубүүдийн үйл ажиллагааны тайлан
- Сургуулийн төсөв, түүний зарцуулалт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутны сайн дурын үйл ажиллагаанд сургууль санхүүгийн дэмжлэг үзүүлдэг. МУБИС-ийн хэмжээнд өнөөдөр 24 клуб идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа ажээ.
- Боловсрол судлалын 4 дүгээр дамжааны оюутнууд “Сайн дурын үйл ажиллагаа” хөтөлбөрөөр хичээлийн судалгааны чиглэлээр зарим нэг ЕБС-тай хамтран ажилладаг байна.

- Эрдэм шинжилгээний хуралд шалгарсан илтгэлийн тоо нэмэгдэж байна.
- 2019-2020 оны 38 оюутны хувьд МУБИС-аас оюутны олон нийтийн оролцоог хангах, олон талт үйл ажиллагааны 7 чиглэлийн үйл ажиллагаанд 60 гаран хувь нь хамрагдсан байна.
- Оюутны сэтгэл ханамжийн судалгаагаар оюутнууд зохион байгуулсан үйл ажиллагаанд сэтгэл хангалуун байна. Өвлийн өдөрлөг зэрэг 2 ажилд оюутнуудын сэтгэл ханамж сул харин бусад 12 үйл ажиллагаанд сэтгэл хангалуун оюутны тоо 60 хувиас дээш үзүүлэлттэй байна.

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- БоСС захирлын тушаалууд
- Сургалтын журам
- Шилжилт хөдөлгөөний судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- БоСС хөтөлбөрөөр нийт 5 оюутан шилжин ирж суралцсан ба гадаадаас 1, МУБИС-ийн бусад сургуулиас 3 оюутан, өөр сургуулиас 1 оюутан шилжин ирсэн. БоСС ангиас 2014-20 оны байдлаар 28 оюутан шилжсэн байна.
- Шилжилт хөдөлгөөн хийсэн шалтгаан нь төлбөрийн боломжгүй, хүндэтгэх шалтгаан, цэрэгт явсан, өөр сургуульд шилжсэн зэрэг болно. Өөр сургуульд шилжсэн шалтгаан нь сонгон судалсан хөтөлбөр, ямар ажил хийх зэрэг талаар ойлголт сул байх, төгссөн хойноо ажил хийх боломжтой мэргэжил сонгосон зэрэгтэй холбоотой байна.

Анхаарах асуудал:

- Анх элссэн 33 оюутнаас 21 оюутан нь хугацаандаа төгссөн байгаагаас харахад хөтөлбөрийн оюутны тогтвортой байдал тааруухан байгааг анхаарах.

Зөвлөмж:

- Тухайн хөтөлбөрийн оюутны тогтвортой байдал буюу retention rate–ийн судалгааг жил бүр тогтмолжуулж, нөлөөлж буй хүчин зүйлийг судалдаг байх.

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын журам
- Сургуулийн захирлын төгсөлтийн тушаал
- Дипломын загвар
- Дүнгийн хавсралт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөлтийн үйл ажиллагаа зохион байгуулах комисс байгуулахдаа бүрэлдэхүүний сургуулийн саналыг үндэслэн төгсөлтийн нэгдсэн үнэлгээний комисс байгуулж, МУБИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулдаг байна.
- Диплом нь МУБИС-ийн Удирдах зөвлөлийн дарга, захирал, төгсөлтийн ерөнхий комиссын дарга буюу сургалт эрхэлсэн дэд захирал, бүрэлдэхүүний сургуулийн захирлын гарын үсэг, МУБИС-ийн тэмдгээр баталгаажих ба дугаар, бүртгэлийн дугаартай байна.
- Бакалаврын сургалтын төлөвлөгөөн дэх ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээлийг бүрэн цуглуулсан оюутныг бакалаврын зэргээр төгсгөдөг ба ерөнхий голч дүн 1.7-оос доошгүй байх шаардлага тавьдаг байна.
- Ажил олгогчидтой хийсэн ярилцлагын тэмдэглэл

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн хүний нөөцийн цогц бодлогын баримт бичиг, хэрэгжилтийн тайлан
- Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин, судалгаа /сүүлийн 5 жилээр/
- Багш суралцагчдын тооны зохистой харьцааны судалгаа /сүүлийн 5 жилээр/
- Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагад нийцсэн байдлын судалгаа.
- Багшийн цагийн ачаалал тооцсон судалгаа
- Багш нарт олгосон урамшууллын судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Уг хөтөлбөрт профессор 1, дэд профессор 3, ахлах багш 1, багш 5, дадлагажигч багш 1, нийт 11 профессор багш нар үйлчилгээ үзүүлдэг. Нийт багш нарын 54.5%-нь эрдмийн зэрэгтэй.

- МУБИС нь багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын талаар тогтсон бодлого, дүрэм журамтай.
- Нэг багшид дунджаар 10 оюутан оногддог.
- Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Анхаарах асуудал:

- Эрдмийн зэрэг хамгаалаагүй багш нарт судалгаа хийх цаг зав гаргаж өгөхөд анхаарч тэдний хэт олон илүү цаг зааж байгаа байдалд дүн шинжилгээ хийж цагийн ачааллыг багасгах.

Зөвлөмж:

- Оюутнуудаас багш нарын ур чадварын талаар сэтгэл ханамжийн талаар авсан судалгааны үр дүнг албан тушаалын зэрэглэл ахиулах, шагнал урамшуулалд тодорхойлоход тусган авч үздэг байх.

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- Багшлахуйн ур чадвар, судалгааны ур чадвар, суралцах хэрэгцээг тодорхойлсон судалгаа, судалгааны дагуу хийсэн ажлын баримт
- Төлөвлөгөө, тайлан
- Багшийг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлж чадавхжуулсан судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийн сурах, мэргэжил боловсролоо дээшлүүлэх хэрэгцээ, шаардлагыг тогтмол судалж, гадаад, дотоодын сургалтад тогтмол хамруулдаг.
- Багш нар өөрийгөө хөгжүүлэх хөтөлбөр 3 жил тутамд боловсруулан эрэлт хэрэгцээгээ тодорхойлон хөгждөг.
- Багш нар гадаадын улс орнуудаас Япон улсын нэр бүхий их дээд сургуулиудад голчлон мэргэжил боловсролоо дээшлүүлж суралцдаг.

Анхаарах асуудал:

- Багш нарынхаа судалгааны чадамжийг улам сайжруулахад анхаарах.

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инновац, ашигтай загвар, патентын тоон судалгаа
- Бодлогын баримт бичиг, дүрэм журам
- Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, судалгааны ажлын тайлан мэдээ, хөтөлбөрт тусгагдсан байдал
- Нийтлэгдсэн бүтээл, судалгааны ажил, эшлэгдсэн тоо
- Эрдэм шинжилгээний ажилд зарцуулсан төсөв, тайлан

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Боловсрол судлал хөтөлбөрийн багш нар Багш боловсролын шинэчлэл, оюутны суралцах хэв шинжийн судалгаа зэрэг чиглэлээр 20 гаруй төсөл, хөтөлбөр дээр шавь нараа дагуулан оролцуулж ажилладаг. -Инновац, патент, ашигтай загвар хараахан гараагүй.
- Тус хөтөлбөрийн багш нар 2014-2019 онд нийтдээ 88 илтгэл, 85 эрдэм шинжилгээний өгүүлэл, 2 нийтлэл, 3 орчуулгын бүтээл, 2 эмхэтгэл, 34 гарын авлага, 20 сурах бичиг, 1 нэг сэдэвт бүтээл хэвлүүлжээ.

Анхаарах асуудал:

- Эдгээр төсөл, захиалгат ажлын санхүүжилтийн хэмжээ, оролцсон оюутны тоо, гарсан үр дүн зэргийг тайланд дэлгэрэнгүй тусгаагүй.

Зөвлөмж:

- Олон улсын болон дотоодын санхүүжилттэй шинжлэх ухаан, технологийн, инновацын төсөл, хөтөлбөрүүдийг нэмж хэрэгжүүлэх.

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- Багшийн өөрийн үнэлгээний тайланг үнэлэх дүгнэх журам, хэрэгжилтийн тайлан
- Багшийн өөрийн үнэлгээний тайлан
- Хөндлөнгийн үнэлгээний дүн
- Багшийн үнэлгээний дагуу авч хэрэгжүүлсэн ажил арга хэмжээний тайлан мэдээ
- Багшийн ажлын хавтас

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУБИС-ийн багшийн албан тушаалын зэрэглэл тогтоох удирдамж, шалгуур үзүүлэлтийн дагуу багш бүр өөрийн ажлын үр дүнг тайлагнан дүгнэж сургуулийн зүгээс 3 үе шаттай хөндлөнгийн үнэлгээ хийлгэсэн.
- Улирал бүрийн эцэст хичээл заасан багшийн ажлын хариуцлага, ёс зүй, заах арга зүй, хичээлийн агуулга, оюутны мэдлэг чадварыг хэрхэн үнэлдэг зэрэг асуултаар сэтгэл ханамжийн судалгаа авч багшийн үнэлгээний нэг үзүүлэлт болгон ашигладаг.

Анхаарах асуудал:

- Залуу багш нарын судалгааны чадамжид онцгойлон анхаарч хөгжүүлэх.
- Багшийн ажлын дэвтэр буюу журнал хөтлөлт, хичээлийн технологийн мөрдөлт, зааж буй хичээлийн агуулгын шинэчлэл, сэдэвчилсэн төлөвлөгөөнд тусгагдсан хичээлийн сэдэв, агуулгыг баримталж заахад анхаарах.

Зөвлөмж:

- Багшийн үйл ажиллагааны талаар оюутнудаас авдаг сэтгэл ханамжийн судалгааны зарим хоёрдмол утга илэрхийлж, үр дүнд сөргөөр нөлөөх асуулт байгааг хамт олноороо ярилцаж засаж залруулах.

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- МУБИС – ийн дотоод зохион байгуулалт
- МУБИС – ийн дотоод журам
- МУБИС – ийн сургалтын журам
- Чанарын баталгаажуулалтын тогтолцооны зураглал
- Хөтөлбөрийн үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд
- Хөтөлбөр боловсруулах удирдамж
- Сэтгэл ханамжийн судалгааны асуулга
- Удирдлагын мэдээллийн систем

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУБИС–ийн хөтөлбөрийн ерөнхий хороо, салбар хороо, дэд хороодууд бүтцийн дагуу ажиллаж, хөтөлбөрийн баталгаажуулалт, хяналт, үнэлгээг хийдэг.
- Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтыг хөтөлбөрийн төлөвлөлт, боловсруулалт, зохион байгуулалт, хэрэгжүүлэлтийн үнэлгээ гэсэн 2 үе шаттайгаар хийж байна.
- Чанарын дотоод баталгаажуулалтын үр дүнд мэргэжлийн бүх хичээлийн хөтөлбөрт сайжруулалт хийсэн байна.

Анхаарах асуудал:

- Чанарын баталгаажуулалтын шалгуур үзүүлэлтүүдийг түвшин бүрээр тодорхойлж, багш нарт нэгдсэн ойлголт өгөх.

Зөвлөмж:

- Чанарын дотоод баталгаажуулалтын шалгуур үзүүлэлтүүд, хөндлөнгийн үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг тодорхой болгож, ил тод болгох

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Илрэл нотолгоо:

- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа
- Төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаа
- Удирдлагын мэдээллийн систем
- Диплом хамгаалсан оюутнуудын мэдээлэл
- Хөтөлбөрийн оюутны тогтвортой байдал

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 1 л удаагийн төгсөлт хийсэн боловч, төгссөн оюутнуудын ажил эрхлэлтийг судалсан байна.
- Төгсөгчдийн мөшгөх судалгааг жил бүр хийхээр төлөвлөсөн байна.

Анхаарах асуудал:

- 1 л удаагийн төгсөлт хийсэн тул, хөтөлбөрийн үр дүнг үнэлэх хангалттай мэдээлэл дутмаг.
- Төгсөгчдийн мэргэжлээрээ ажиллаж буй хувь доогуур байгаад шинжилгээ хийх.
- Диплом хамгаалж буй оюутны тоо сургуулийн журамтай холбогдуулан цөөхөн байгааг мэргэжлийн онцлогтой уялдуулах

Зөвлөмж:

- Судалгааны арга зүй эзэмшсэн байх нь төгсөгчийн загварын гол үзүүлэлт тул, оюутнуудаар диплом бичүүлэх боломж олгох. Төгсөгчдийн ажил эрхлэлт, ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгааг цаашид тогтмол хийх.

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Төгсөгчдийн ажиллаж буй ажлын байрны талаарх мэдээлэл, судалгаа
- ASIIM – ийн шинжээчдээс өгсөн дүгнэлт, зөвлөмж
- ОУ–ын магадлангийн шинжээчдийн өгсөн зөвлөмжийн дагуу гүйцэтгэх ажлын төлөвлөгөө

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлээд удаагүй ч хөндлөнгийн магадлан итгэмжлэл хийлгэхээр ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- ОУ – ын магадлан итгэмжлэлд хамрагдсан бусад хөтөлбөрийн хувьд шинжээчдийн багаас өгсөн нийтлэг зөвлөмжийн дагуу өөрийн хөтөлбөрийг үнэлж үзэх.

Зөвлөмж:

- ОУ–ын магадлан итгэмжлэлд хамрагдсан бусад хөтөлбөрийн хувьд шинжээчдийн багаас өгсөн нийтлэг зөвлөмжийн дагуу Боловсрол судлал хөтөлбөрт сайжруулалт хийх.
- Бакалавр, магистр, докторын түвшний төгсөгчийн загварт судалгаа шинжилгээний ур чадварын түвшний ялгааг тодорхой харуулах.

ДУГНЭЛТ

МУБИС-ийн Боловсрол судлалын сургуулийн Боловсрол судлал хөтөлбөр

№	Шалгуур	Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Шалгуур 1	1.2; 1.3	1.1		Боловсрол судлалын салбарын эксперт болон оролцогч талуудыг бүрэн оролцуулж, хөтөлбөрийн хэрэгцээг тодорхойлоогүй.
2	Шалгуур 2	2.1;2.2	2.3		Оюутны мэдлэг, чадварыг үнэлэх үнэлгээний нэгдсэн сангийн бүрдэл дутуу, даалгаварууд гол төлөв мэдлэгт суурилсан байна.
3	Шалгуур 3	3.1; 3.2; 3.3			
4	Шалгуур 4	4.1; 4.2; 4.4; 4.5	4.3		Тэнхимийн төсөв байхгүй, сургуулийн нэгдсэн төсөвт үйл ажиллагааны зардлуудаа тусгадаг.
5	Шалгуур 5	5.1; 5.2;5.3			
6	Шалгуур 6	6.1; 6.2; 6.3; 6.4			
7	Шалгуур 7	7.1	7.2; 7.3		Хөтөлбөрөөр нэг л удаагийн төгсөлт

					хийсэн бөгөөд хөтөлбөрийн үр дүнг үнэлэхэд төвөгтэй бөгөөд хөтөлбөрт тасралтгүй сайжруулалт хийгдэж байна.
	Дүгнэлт	Шалгуур 1 – бүрэн хангасан Шалгуур 2 – бүрэн хангасан Шалгуур 3 – бүрэн хангасан Шалгуур 4 – бүрэн хангасан Шалгуур 5 – бүрэн хангасан Шалгуур 6 – бүрэн хангасан Шалгуур 7 – хэсэгчлэн хангасан			
					БҮРЭН ХАНГАСАН

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг МУБИС – ийн боловсрол судлалын сургуулийн “Боловсрол судлал” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг БОЛОВСРОЛЫН чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг: С.Эрдэнэтуул

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг: Ю.Хорлоо

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг: С.Санжаабадам

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

Сургуулийн нэр	МУБИС, Боловсрол судлалын сургууль
Хөтөлбөрийн нэр	Боловсрол судлал
Хөтөлбөрийн индекс	D011101
ЗӨВЛӨМЖ	
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	Тухайн мэргэжлийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг экспертүүдийн оролцоотойгоор тодорхойлж, оролцогч талуудаас авах судалгааг тогтмолжуулах. Төгсөгчийн загварт туссан зохицуулагч гэсэн нэрийг өөрчилж, тохиромжит нэрийг оноох. Хөтөлбөрийн агуулга боловсрол судлал гэхээсээ илүү сургалт судлалын хичээлүүд давамгайлж байгааг анхаарч, цаашид боловсролыг нийгмийн орчинтой нь уялдуулан судлах чадварыг олгоход чиглүүлэх.
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	Суралцагчдын судалгааны ур чадварыг сайжруулах тал дээр анхаарч, судалгааны арга зүй хичээлээс гадна бусад хичээлүүдээр судалгаа, шинжилгээний арга зүй суулгах даалгавруудыг гүйцэтгүүлэх, судалгааны программ хангамж дээр ажиллах чадварыг нь нэмэгдүүлэх.
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	Боловсролын хүрээлэн, багшийн хөгжлийн институт зэрэг боловсролын судалгаа шинжилгээнд чухал байр суурь эзэлдэг байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх.
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байранд бэлтгэх чиглэлээрх зөвлөх үйлчилгээг сайжруулах.
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт, хөтөлбөрийн матрицад чадварын түвшинг ялгаатай байдлаар оруулах. Бакалавр, магистр, докторын түвшний судалгааны ур чадварын ялгаатай байдлыг төгсөгчийн загварт тодорхой харуулах.
ШААРДЛАГА	
1.1	Бакалавр, магистрын түвшний босоо холбоог тодорхой харуулж, төгсөгчдийн карьерын замналын боломжит хувилбар, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн таамаглалыг тооцох
2.3.	Даалгаврын найдвартай болон баталгаат чанарыг хангах аргачлалыг хөгжүүлэх, энэ чиглэлээр багш нараа чадавхжуулах ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх. Даалгаварын санг бүрдүүлэхдээ кейсийн санг бүрдүүлэхэд анхаарах.
4.3.	<ul style="list-style-type: none"> • Орлогын эх үүсвэрийг олон хувилбартай болгох, солонгоруулах тал дээр багш нарыг идэвхжүүлэх. • Судалгаанд суурилсан их сургууль болон хөгжих эрхэм зорилгын хүрээнд эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулах зардлын хувийг нэмэгдүүлэх.
7.2	Судалгааны арга зүй эзэмшсэн байх нь төгсөгчийн загварын гол үзүүлэлт тул, оюутнуудаар диплом бичүүлэх боломж олгох.

7.3	Төгсөгчдийн ажил эрхлэлт, ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгааг цаашид тогтмол хийх. ОУ–ын магадлан итгэмжлэлд хамрагдсан бусад хөтөлбөрийн хувьд шинжээчдийн багаас өгсөн нийтлэг зөвлөмжийн дагуу Боловсрол судлал хөтөлбөрт сайжруулалт хийх.
-----	---

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Нэр	Албан тушаал	Зэрэг цол	Ажилласан жил	Заадаг хичээл
1	Г.Баярмаа	Тэнхимийн эрхлэгч	Ph.D	33	Хөтөлбөрийн хөгжил, боловсролын үнэлгээ
2	Ш.Ичинхорлоо	проф	Ph.D	33	Боловсролын социологи, философи
3	Р.Намжилдавга	дэд проф	Ph.D	28	Удирдах ажилтны ёс зүй, ажлын байранд бэлтгэх
4	Л.Ариунжаргал	Багш	Ph.D	7	Боловсролын маркетинг, боловсрол судлаачийн удиртгал
5	Э.Мөнхбат	Багш	Магистр	15	Боловсролын сайн дурын үйл ажиллагаа
6	Б.Ононтуул	Багш	Магистр	9	Төслийн менежмент
7	П.Алтанцэцэг	Багш	Магистр	32	Зөвлөх ажлын арга зүй
8	С.Энхтүвшин	ахлах багш	Магистр	32	Харьцуулсан боловсрол судлал, сургууль судлал
9	Ч.Байгалмаа	дэд проф	Ph.D,	31	Боловсролын бодлого, мэргэжлийн англи хэл

II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал
1	Г.Сувданцэцэг	2	Дотуур байранд амьдардаг.
2	Л.Бүрэнбаяр	2	Голч дүн өндөр
3	Ц.Алтансүх	2	
4	Т.Ариунтамир	2	Голч дүн бага, дотуур байранд амьдардаг.
5	Д.Мөнхтөр	2	Голч дүн дундаж
6	О.Ижилцэцэг	3	Голч дүн доогуур
7	Б.Мөнхгэрэл	3	Дотуур байранд амьдардаг, голч дүн өндөр
8	Б.Мөнхжин	3	
9	Г.Солонго	3	

10	Ш.Энхжин	3	Голч дүн доогуур
11	М.Пунсалмаа	4	Дотуур байранд амьдардаг.
12	Г.Нандин-Эрдэнэ	4	
13	Б.Бумдарь	4	Дотуур байранд амьдардаг.
14	Ц.Эсүжин	4	Голч дүн өндөр
15	А.Ганжаргал	4	Голч дүн доогуур

III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Байгууллага	Албан тушаал
1	Г.Золбоо	“Ким” боловсролын төв	Сургалтын менежер
2	Мөнхзаяа	Баянгол дүүргийн “Сэтгэмж” цогцолбор сургууль	захирал
3	Чимэддулам	Орхон аймгийн 2 – р сургууль	Захирал
4	Цэндмаа	Дорноговь аймгийн Айраг сумын цэцэрлэг	Арга зүйч
5	Х.Долгормаа	SICA Mongolia судалгааны байгууллага	Мэдээлэл цуглуулалт, боловсруулалтын хэлтсийн захирал

IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага	Албан тушаал
1.	Ч.Ариунтуяа	2019	Ажил хайж байгаа	
2.	Г.Бадамцэцэг	2019	Монре даатгал	Даатгалын төлөөлөгч
3.	Э.Будсүрэн	2019	SICO судалгааны байгууллага	Судалгааны мэргэжилтэн
4.	Э.Жаргалмаа	2019	Ажил хайж байгаа	
5.	Д.Жүгдэрмаа	2019	Эрдэнэт Ерөнхий боловсролын сургууль	Хүүхдийн хөгжил хариуцсан мэргэжилтэн
6.	О.Мягмарчулуун	2019	Улаанбаатар зам засвар, арчлалтын газар	Дотоод ажлын мэргэжилтэн
7.	Б.Лхамноржин	2019	КИМ боловсролын төв	Мэдээллийн менежер
8.	Г.Оюун-Ундрах	2019	БГД-ийн Сэтгэмж цогцолбор сургууль	Архив бичиг хэргийн ажилтан
9.	О.Хонгорзул	2019	Ажил хайж байгаа	
10.	Б.Хосчимэг	2019	МУБИС-ийн БСС-ийн боловсрол судлал арга зүйн тэнхим	Туслах багш

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал
/албан бичгийг оруулах/



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛЬ
БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН СУРГУУЛЬ
14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Бага тойруу, Утас: 7012 0013, http://www.msue.edu.mn

Боловсрол № 1/54
танай _____-ны № _____-т

Шинжээчийн тайлантай танилцсан
тухай

БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНД

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн шинжээчид МУБИС-ийн Боловсрол судлалын сургуульд 2020 оны 5 дугаар сарын 28, 29-ний өдрүүдэд ажиллаж, Боловсрол судлалын бакалаврын сургалтын хөтөлбөр (D011101)-ийн өөрийн үнэлгээний тайлан, холбогдох илрэл, нотолгоотой танилцсан билээ.

БМИҮЗ-өөс 2020 оны 6 дугаар сарын 12-ны өдөр ирүүлсэн Шинжээчийн үнэлгээний тайлантай хөтөлбөрийн өөрийн үнэлгээний баг танилцаж, тайланд тусгасан анхаарах зүйл, зөвлөмжийг хүлээн авч байна.

Цаашид өгсөн заавар, зөвлөмжийн дагуу "Боловсрол судлал"-ын хөтөлбөрийг тасралтгүй засаж, сайжруулах төлөвлөгөө гарган, тайланд тусгагдсан зөвлөмж, анхаарах зүйлс, дүгнэлтийн дагуу хөтөлбөрийн тасралтгүй хөгжлийг ханган ажиллах болно.

Хамтран ажилласан Та бүхэнд баярлалаа.

ЗАХИРАЛ, ДЭД ПРОФЕССОР *Г.Цогзолмаа* Г.ЦОГЗОЛМАА



VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо)
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)
[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/